



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 230

Улаанбаатар хот

**Аж ахуйн үйл ажиллагааны
тусгай зөвшөөрлийн тухай**

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.5 дахь заалт, улсын байцаагчийн 2019 оны 38-07-076/108 тоот дүгнэлтийг үндэслэн “Замт моторс” ХХК-д Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК-ийн байршилд автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.12 дахь заалтын дагуу энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалтыг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 163 дугаар тушаалаар үйл ажиллагааг нь түдгэлзүүлсэн энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.


4. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй гэрээ байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

САЙД  Б.ЭНХ-АМГАЛАН

1118268062 5919487 C5T9512

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 07 сарын 03 өдрийн 230
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




1118252063 5919487 CEST8517

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Байршил
1.	"Мэндийн говь" ХХК	2559412	Өмнөговь. Даланзадгад сум
2.	"ДБУ" ХХК	5364035	СХД. 32 хороо. "Олон улсын худалдаа логистикийн төв" ХК
3.	"Эрчэс хурд транс" ХХК	6436013	БЗД. 8 хороо "Таван ган трейд" ХХК-ийн байр
4.	"Хан шанью" ХХК	6420443	БГД. 3 хороо. "Уран ган" ХХК-ийн байр
5.	"Хан модун" ХХК	6443796	Өмнөговь аймаг. Цогтцэций сум

-----ooOoo-----

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 07 сарын 03 өдрийн 230
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



д/д	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Тусгай зөвшөөрөл олгосон огноо/дугаар
6.	"Альфа солбилцол" ХХК	5324793	2017/007
7.	"Жи Эл Ти" ХХК	5177472	2017/010
8.	"Төгрөг дугаар" ХХК /Баянзүрх/	5838657	2017/012
9.	"Аталар" ХХК	5658683	2017/014
10.	"Өгөлэд хайрхан" ХХК	5852668	2017/015
11.	"Рэс" ХХК	5211964	2017/002
12.	"Ньюпрезидент холдинг" ХХК	5485339	2016/003

-----ooOoo-----